



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/18.

Өвт

Засаг даргын Тамгын газрын өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын комисс байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” 9 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/228 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Ч.Батдулам (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

С.Ганхүлэг (Засаг даргын Тамгын газрын нярав)

И.Маралмаа (Газрын даамал)

Г.Сугар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Ж.Энхзаяа (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бичиг хэргийн ажилтан)

Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

2. Засаг даргын Тамгын газрын өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг батлагдсан удирдамж, маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн Орон нутгийн өмчийн газарт хургуулэхийг (Э.Дашдулам)-д даалгасугай.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ

